

Үйлийг тоочин дүрсэлсэн эхээс
уран дүрслэл, хэлцийн утга,
үүргийг тодруулах



Хичээлийн зорилго

- ✓ Эхээс уран дүрслэлийн үүргийг тодруулах
- ✓ Эхээс хэлцийн утга, үүргийг тодруулах






"Гэрээсээ сургууль орох замд "гэсэн сэдвийн хүрээнд бяцхан аяллын тэмдэглэл бичье.

- + Гэр сургууль хоёрын хооронд юу, юу байдгийг саная.
- + Үзсэн харсан зүйлийнхээ талаар найз нөхдийнхөө анхаарлыг нь татаж, сэтгэлийг нь хөдөлгөхөөр яаж уран сайхан , дүрсэлж бичихээ бодоорой.





Юу, юу харагдаж байна
вэ?

Манан будан
хөшиглөсөн уул..
Өндөр өндөр барилга

Юу үнэртэж байна вэ?

Аргалын утаа
Өглөөний цэвэр тунгалаг
агаар
Борооны дараах чийг

Юу сонсогдож байна вэ?

Шувуудийн жиргээн
Навчсын чимээ
Машины нүргээн
Их хотын шуугиан

Юмс үзэгдлийн юуг нь
чухалчилж дүрслэх вэ?

Ажигласан зүйлээс чинь
нөхдөдөө дүрслэн
бичмээр сонин сайхан
зүйл юу байна вэ?

Ямар, ямар үг хэллэг
илүү хэрэглэх вэ?

Мэдрэмж, сэтгэгдлээ
хаана нь оруулж бичих
вэ?

Уншиж буй хүнд яаж
сонирхолтой болгох вэ?



“ЭКВАДОРТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ”-ээс



... Уулын сүрд дарагдан бидний зүрх түгшлээ. Гурван мянган метр өргөгдсөн их уулын сүрлэг хяр дээгүүр, гүн ангал, хадан хясааны ирмэгээр, могой мэт тахиралдсан нарийхан замаар бидний суусан автобус уухилан дээшилсээр байлаа. Зарим газар замын хажуугийн эгц энгэр нурж бөөн чулуу шороо овоологдсон, зарим газар үер бууж замын дундуур сэт цохигдсон байлаа.

Тэр бүхнийг тойрох, дээгүүр нь дэнжигнэн тэгнэх, гулсан хий эргэх зэргээр гэтлэн давахын тулд автобус, жолооч хоёр зовон зүдэж, дотор нь суусан бид айн бэмбэгнэн явсаар арай гэж даваан дээр гарав. Эргэн харахад тэртээ дор ширүүн урсгалт гол, хадан хясаа, гүнзгий хавцал дундуур гаслах мэт бархиран урсаж, алсад Антисанаа гэдэг сүрлэг цаст уулын орой цайвалзан цухуйж үзэгдлээ.

Эквадорын арван найман мужийн нэг болох Имбабура орохоор бид ийнхүү бэдэрч явна. Даваан дээр гартал алсад бас шовх цэнхэр уулс сүндэрлэн давхарлаж, хэрэм мэт хүрээлэн харагдлаа. Бидний өмнүүр хөндөлдөн цэнхэртэх уулсаас янагш цэлгэр ногоон хөндий мэлтийж, тэртээ үзүүрт нь тогорууны нүд шиг нуур гялтайж байлаа. Даваан дээр гарч тонгоймогц автобус зогсоход бид ухасхийн үүд зүглэлээ.

Биднийг газардамц өмнөөс минь сонин хувцастай нэгэн эр утган ирлээ. Хөхөлбий бор царайтай, намхан нуруутай инка хүн ажээ. Мөрөндөө гитар хөгжим зүүжээ. Өвдөгнөөсөө доош салгагар хүрэн үстэй баавгайн годын сарвууг нь уруу харуулан унжуулсан нь мөчид харвал, хоёр хөл нь баавгайнх шиг юм. Инка хүмүүс баавгайн хумс бүхий сарвуутай годоор хийсэн уутыг өвдөгнөөс доош шилбээ дагуулан унжуулж өмд мэтээр өмсдөг байна. Анх харахад цочмоор сүртэй үзэгдэнэ. Тийнхүү бидэнтэй даваан дээр учирсан инка хүн гитараа хөндлөн барьж зогсоод эртний индейчүүдийн сонин дууг хөгжимдөж эхэллээ. Бид сониучирхан түүнийг тойрч зогсоод дууг чгнав. Уянгалаг аялгуу байлаа. Гунигтай, анигар хүрэн нүдэнд нь уярал тодорч, үрчлээт магнай нь үе үе тэнийж, өвдөг рүүгээ унжуулсан баавгайн годны сарвуу нь үл мэдэг чичрэгнэнэ. Нэг үе гаслан уйлах шиг, нэг үе хилэгнэн зүхэх шиг, тэгснээ эхэр татан зогьсох адил дуу аялгуу гитарын утаснаас цацагдан түгж, их уулын сийрэг агаарт тодхон цуурайтаж байлаа.

... Сүүлчийн бизон эсвэл сүүлчийн оронго үхэж тийнхүү аль нэгэн ховор амьтан байхгүй болсон тухай мэдээг далхий дахин эмгэнэн сонссон нь олонтоо. Гэвч индейчүүдийг ийм гунигт тавиланд хүргэхийг хүн төрөлхтөн хэрхэвч зөвшөөрөх ёсгүй. Эквадорын индейчүүд ...мөхөж сөнөхийн даваанд хүрсэн үедээ 1823 онд маршал Сүкрегийн удирдсан зэвсэгт тэмцлийн ачаар аврагджээ. “Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургана” гэгчээр харийн тонуулчид индейчүүдийг дуусгаж чадсангүй, нүүгээгээ үүрээд далайн чанадыг зүглэх цаг нь иржээ.

... Индейчүүд ирээдүйдээ итгэл алдсангүй. “Кунан кайа, Майжан, Пуньяа, инти чинг танга” гэж дуулсаар иржээ. Энэ нь “Өнөө юу, маргааш уу? Өөр нэг өдөр үү? Наран гарахдаа л нэг гарна” гэсэн утгатай юм санжээ. Индейчүүдийн жаргалын нар гарах өдөр ойрхон болжээ.

(Л.Түдээ)

Эхээс уран дүрслэл, хэлцийг ялган бичье

Уран дүрслэл

- Могой мэт тахиралдсан нарийхан зам- **адилтгал**
- Шовх шовх цэнхэр уулс сүндэрлэн давхарлаж, хэрэм мэт хүрээлэн харагдлаа- **адилтгал**
- Ширүүн урсгалт гол, хадан хясаа, гүнзгий хэвцал, дундуур гаслах мэт бархиран урсаж – **амьдчилал**
- Тэртээ үзүүрт тогорууны нүд шиг нуур гялтайж – **адилтгал**
- Нэг үе гаслан уйлах шиг, нэг үе хилэгнэн зүхэх шиг, тэгснээ эхэр татан зогьсох адил дуу аялгуу- **адилтгал, амьдчилал**

Хэлц

- Зүрх түгшлээ.- **сэтгэл санаа тавгүй болох**
- Идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут ургана – **эцэстээ шударга үнэн дийлнэ**
- Итгэл алдсангүй- **мохоогүй, итгэлтэй байх, тууштай байх**
- Наран гарах – **Хүсэж мөрөөдөж байсан зүйл нь сэтгэлчлэн бүтэж баяр хөөр болох, баярлах**

Зохиогч яагаад уран дүрслэл, хэлцийг эхэд сонгон хэрэглэсэн бэ? Үүрэг нь юу вэ?

- ✓ Эхэд далд ёгт, өргөн дэлгэр, гүн гүнзгий санааг илэрхийлэхийн тулд хэлцийг хэрэглэсэн.
- ✓ Зохиогч адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал зэрэг уран дүрслэлийг аялсан газрын онцлогийг уншигчдын сэтгэлд буутал дүрслэхийн тулд ашигласан.

Хэлцийн үндсэн шинж

- + Уран дүрслэлээр бүтнэ
- + Гол санаа нь бодит хэрэг явдлаас үүдэж, утга шилжсэнээс үүснэ.
- + Илрэх хэлбэр нь товч.
- + Утга санаа нь далд, ёгт, өргөн дэлгэр, гүн гүнзгий, сургамжтай байна.
- + Үндэстний ахуй, ёс заншил, соёл сэтгэлгээний онцлогийг тусгасан байна.

Уран дүрслэл

+ Адилтгал:

Нэг юм үзэгдлийн шинжийг өөр төстэй юм үзэгдэлтэй зэрэгцүүлэн тавьж дүрслэх (шиг, мэт, адил, шуу, втар, өөрцгүй, чинээ, магад) дүрслэх арга юм.

+ Ихэсгэл:

Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох бололцооноос хэт ихэсгэсэн давуулж дүрслэх арга

+ Багасгал:

Юм үзэгдлийн аль нэг шинж чанарыг бодитой байж болох бололцооноос хэт багасгасан дүрслэх арга

Зургийг ажиглаад, төсөөлөн бодъё



Алтай



Миний бие баруун Алтайн уулсыг хоёр жилийн өмнө анх удаа үзээд дэргэдээ байгаа, тэнгэртэй сайхан энэ ууланд өдий хүртэл хүрч ирэх сүйхээгүй явсандаа ихэд гутарч билээ. Энэ бол үнэндээ ашиггүй өнгөрүүлсэн цагаа эргэж харамссан харамсал байлаа...

Баяннуур хэмээх тохилог суурины хаяанд Ховд голын тавилангаар гарч байхад, байгалийн сүр хүчин, уян зөөлөн байдал, давтагдашгүй гоо үзэсгэлэн аль аль нь нэг хэсэгхэн газар тэгж хослон тогтсоныг гайхмаар байв. Хүрэн улаан, ногоовтор, хөх саарал өнгийн хадан уулс голын тунгалаг ногоон усанд тольдон гаднаас үзэхэд амьдралгүй мэт тэр баргар бөгөөд эгц цавчим уулсаар хавчигдсан хөндийд шим ертөнцийн хүчийг зориуд үзүүлсэн үзмэр мэт намжаа их улиас, үрэл, чацарганын мод улайран шаргалтаж байв. Ховд голын баруун биед намрын ухаа саарал униар татсан нэгэн цуваа хүрэн хүрмэн уул, түүний цаадтай нэгэн цуваа хөх хадан уул, бас түүний цаана өөр нэгэн цуваа хар уул, бүр цаана нь Цамбагаравын мөнх цаст оргил сүүдэр талдаа хөх цэнхэр, наран талдаа гялгар цагаан туяатай байгаа тэр бүхнийг үгээр эвлүүлэн хэлэх байтугай өнгөөр ялган зурахад ч бэрх ажээ...

...Газар дэлхий дээр ямар олон янзын будаг байдгийг тэгэхэд бодсон юм. Адгийн наад зах нь салхины өнгийг төсөөлж болох байв. Ховд голын хөндийд намуухан шар салхи сэмхэн хэсүүчилж байхад, тэртээ өндрийн хадан цохионд хар салхи, Цамбагаравын хяр оройгоор бол дун цагаан салхи салхилж байх шиг санагдсан...

. .. Нисэх онгоцоор Ховд хотоос Өлгий хот орж явахад Цамбагаравын дүлий цагаан оргил зэрэгцээд ирэхийн үес тэр оргилын хүйтэн жихүүн амьсгал онгоцны бөөрөөс нэвт үлээх мэт ар нуруу руу хүйт оргиж байв. Тэртээ умар зүгт Хархираа, Түргэний шовх шовх оргилууд гялбалзан харагдана.Тэдгээрийн наад захынх нь асар том болор талстууд мэт гэрэл сацруулан, цаад захынх нь уул, үүл алин болох нь ялгагдахгүй хөхрөн зурайж байв.Тэр оргилууд газраас ургаж тогтсон биш тэнгэрээс бууж тогтсон мэт ажээ. Ийм сүрлэг сайхан ертөнцөд замаа олж, эцсээ хүртэл явах эрэлхэг зориг хэрэгтэй бус уу гэж бодогдсон. Энэ сүрлэг сайхан ертөнцөд уран бүтээлч, бичгийн хүн өчүүхэн атаархалд автагдан бухимдахгүй гүдэсхэн явах ёстой. Би өөртөө ногдсон уулын оргилд хүрэхээр явна. Та намайг сэрээж тус болов. Алтай хайрхан уул минь! гэж дотроо шивнэн явж билээ. (С.Эрдэнэ)

Эхийн гол санааг цогцолбороор илэрхийлье.

01

Энэ бол үнэндээ ашиггүй өнгөрүүлсэн цагаа эргэж харамссан харамсал байв.

02

Байгалийн сүр хүчин , уян зөөлөн байдал, давтагдашгүй гоо үзэсгэлэн аль аль нь нэг хэсэгхэн газар тэгж хослон тогтсоныг гайхмаар байв.

03

Газар дэлхий дээр ямар олон янзын будаг, байдаг, наад зах нь салхины өнгийг төсөөлж болох байв.

04

Ийм сүрлэг сайхан ертөнцөд замаа олж, эцсээ хүртэл явах эрэлхэг зориг хэрэгтэй бус уу гэж бодогдсон.


Эхийн сэдэв:

Байгалийн сайхан

Эхийн гол санаа:

Байгаль бол сүрлэг сайхан юм.

Аян замын тэмдэглэлийг загварын дагуу задалж ярилцъя



Сайн дүрсэлж бичсэн аян замын тэмдэглэл нь тухайн газар орны сайхныг таван мэдрэхүйгээрээ хүртэх мэдрэмжийг уншигчдад өгдөг.

Байгалийн юмс үзэгдлийг зэрэгцүүлэн тоочиж дүрсэлснийг зураглая

Байгалийн сүр хүчин
Уян зөөлөн байдал
Давтагдашгүй гоо үзэсгэлэн

хэсэгхэн газар тэгж хослон тогтсон...

Хүрэн улаан
Ногоовтор
Хөх саарал өнгийн
Амьдралгүй мэт
Баргар
Эгц цавчим

Уулсаар
хавчигдсан

Хөндийд

Шим
ертөнцийн
хүчийг
зориуд
үзүүлсэн
үзмэр мэт
намжаа их

Улиас мод
Үрлийн млд
чацарганы мод

Улайран
шаргалтаж
байв.

...цуваа хүрмэн уул
...цуваа хөх хадан уул
...цуваа хар уул

Бүр цаана нь

Цамбагаравын мөнх цаст оргил
сүүдэр талдаа хөх цэнхэр,
наран талдаа гялгар цагаан
туяатай байгаа тэр бүхнийг

...өнгөөр ялган
зурахад ч бэрх
байв.

...тэртээ өндрийн хадан цохионд
хар салхи,
Цамбагаравын хяр оройгоор дун
цагаан салхи

Салхилж байх шиг
санагдсан.

Юмс үзэгдлийг зэрэгцүүлэн тоочих нь
тоочин дүрслэх нэг арга юм.

Байгалийн харагдах байдлыг дүрслэхдээ яагаад тэмдэг нэрийг ашигласныг тодруулъя

Хүрэн улаан,
ногоовтор,
хөх саарал
амьдралгүй мэт баргар
эгц цавчим
цуваа хүрэн
хүрмэн
цуваа хөх
цуваа хар

УУЛ

УС

тунгалаг ногоон

үзмэр мэт намжаа их

УЛИАС

УНИАР

намрын ухаа саарал

мөнх цаст
сүүдэр талдаа хөх цэнхэр
наран талдаа гялгар
цагаан туяатай
дүлий цагаан

ОРГИЛ

- Юмс үзэгдлийг нүдэнд харагдтал дүрслэхэд оновчтой сонгосон тэмдэг нэр нь уг юмыг илүү өвөрмөц, тодорхой болгодог.
- Зохиогч тэмдэг нэрийг уншигчийн сэтгэлийг хөдөлгөх, байгалийн сүр хүч, түүнийг биширч буй тухай өөрийн үзэл бодол, сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэх зорилгоор хэрэглэсэн.
- Тэмдэг нэрээр бичигчийн хандлага үнэлэмж илэрдэг.

Баяннуур хэмээх тохилог **СУУРИН**



Амьдралгүй мэт тэр баргар бөгөөд эгц цавчим уулсаар хавчигдсан **ХӨНДИЙ**



Шим ертөнцийн хүчийг зориуд үзүүлсэн үзмэр мэт намжаа их **УЛИАС**



САЛХИ (Ховд голын хөндийд намуухан шар салхи сэмхэн хэсүүчилж, тэртээ өндрийн хадан цохионд хар салхи, Цамбагаравын хяр оройгоор бол дун цагаан салхи салхилж...)



УУЛС (Хүрэн улаан, ногоовтор, хөх саарал, хадан цуваа хүрэн хүрмэн, цуваа хөх хадан, цуваа хар, амьдралгүй мэт, баргар, эгц цавчим)



АЛТАЙН УУЛС



Үрэл, чацарганы **МОД** улайран шаргалтаж байв.



Намрын ухаа саарал **УНИАР**



ОРГИЛ (Цамбагаравын мөнх цаст оргил сүүдэр талдаа хөх цэнхэр, наран талдаа гялгар цагаан туяатай, Цамбагаравын дүлий цагаан оргил, Хархиргаа, Түргэний шовх шовх оргилууд гялбалзан, асар том болор талстууд мэт гэрэл сацруулан, цаад захынх нь уул, үүл алин болох нь ялгагдахгүй хөхрөн зурайж, Тэр оргилууд газраас ургааж тогтсон биш тэнгэрээс бууж тогтсон мэт.)



Оргилын хүйтэн жихүүн **АМЬСГАЛ**



Үгээр эвлүүлэн хэлэх байтугай өнгөөр ялган зурахад ч бэрх ажээ...
...Газар дэлхий дээр ямар олон янзын будаг байдгийг тэгэхэд бодсон юм.

- + Зохиолч аян замын тэмдэглэлдээ юу, юуг дүрсэлснийг ажиглаарай.
- + Байгалийн юмс үзэгдлийг дүрслэхдээ хэрэглэсэн уран дүрслэлийн утга, үүргийг тайлбарлаарай.



Хичээлээ дүгнэе

- + Хэлц нь найруулгыг утга төгөлдөр, товч тодорхой, уран яруу, сонсголонтой сайхан болгоход хэлцийг оновчтой сонгон хэрэглэх нь чухал. Хэлц нь эхэд далд ёгт, өргөн дэлгэр, гүн гүнзгий санааг илэрхийлдэг.
- + Уран дүрслэл нь эхийг сонирхолтой амьтай яруу сайхан болгоно. Тиймээс зохиогч адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал зэрэг уран дүрслэлийг аялсан газрын онцлогийг уншигчдын сэтгэлд буутал дүрслэхийн тулд ашигладаг.

Гэрийн даалгавар

Сурах бичиг 75 –р хуудас дасгал 15 а ажиллах .



Анхаарал тавьсанд баярлалаа.

